



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/687

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аймгийн онцгой комиссын хурлын тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор, Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэрэгцээний нөөцөд 2019-2020 оны өвс бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа Мянгад сумын иргэн Намхайгийн Нямбаярт 1000 ширхэг прессийн үнээр 5000000 төгрөгийг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 5000000 төгрөг /таван сая/-ийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тогтоосон хугацаанд өвсний нөөцийг бүрдүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/687/ Ch.  
02 03385